



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 356

Улаанбаатар хот

“Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг шинэчлэн
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг шинэчлэн батлах тухай Хорооны 2009 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

3. Сайн дурын даатгалын хэлбэр шинэчлэн батлагдсантай холбогдуулан даатгалын компаниудад дараах ажлыг үүрэг болгосугай:

1/ Даатгалын хэлбэрт хамаарах даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр борлуулахаас өмнө Хороонд бүртгүүлэх;

2/ Даатгалын компанийн улирал, жилийн санхүүгийн нэмэлт тайланд орлого зарлагыг хэлбэрээр гаргахдаа энэ жагсаалтаар ангилж тусгах;

3/ Даатгалын бүтээгдэхүүний даатгалын хураамжийн хэмжээг актуар тооцооллоор тооцох;

4/ Даатгалын бүтээгдэхүүний жагсаалтыг жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх.

4. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компаниудад орон сууцны урт хугацааны зээл (моргэйж)-ийн гэрээний зээлдэгчийн амь насны даатгалын гэрээ шинээр байгуулахгүй байхыг анхааруулсугай.

5. Энэ тогтоолын 4 дүгээр заалтын талаар арилжааны банкуудад мэдэгдэх, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Сайн дурын даатгалын хэлбэр

Даатгалын ангилал	Даатгалын хэлбэр	Даатгалын хэлбэрийн тайлбар
1.Ердийн даатгал	1.1.Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлын даатгал хамаарна. Зээлдэгчийнамь нас, осол, гэмтлийн даатгал энэ хэлбэрт хамаарахгүй.
	1.2.Хөрөнгийн даатгал	Гал, ус, байгалийн болон бусад гэнэтийн аюул, ослын улмаас энэ жагсаалтын 1.3-1.8-д зааснаас бусад хөрөнгөнд хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Бэлэн мөнгөний болон зээлийн барьцаа хөрөнгийн даатгал энэ хэлбэрт хамаарна. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.3.Авто тээврийн хэрэгслийн даатгал	Авто тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохиролучрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.4.Ачааны даатгал	Аливаа тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй ачаанд гэмтэл, хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.5.Барилга угсралтын даатгал	Барилга угсралтын явцад гэнэтийн аюул ослын улмаас угсралт, цутгалт, өрлөгийн ажилд хохирол гарахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Угсралтын ажилд ашиглагдах машин, тоног төхөөрөмж, түр сууцыг даатгуулж болох ба төсөвт өртөг дээр үнэлгээг нэмэгдүүлж даатгана. Аливаа

		хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.6.Газар тариалангийн даатгал	Гал, түймэр, үерийн ус зэрэг байгалийн болон бусад эрсдэлийн улмаас газар тариалангийн даатгалын тохиолдол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.7.Мал амьтдын даатгал	Аливаа осол, эрсдэлээр мал амьтан хорогдсоны улмаас даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.8.Агаарын хөлгийн даатгал	Аливаа ослын улмаас агаарын хөлгийн их биед хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал болон бусад хариуцлагын даатгал, агаарын хөлөгт ачсан ачааны даатгал энэ хэлбэрт хамаарахгүй.
	1.9.Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	Авто тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглахтай холбоотой аливаа осол, гэмтлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан нөхцөлд даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал.
	1.10.Хариуцлагын даатгал	Аливаа этгээдийн санамсар болгоомжгүй буруутай үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий энэ жагсаалтын 1.9, 1.15, 1.16-д зааснаас бусад хариуцлагын даатгал. Барилга угсралтын хариуцлагын даатгал үүнд хамаарна.
	1.11.Санхүүгийн даатгал	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Бизнес тасалдлын даатгал үүнд хамаарна.
	1.12. Зээлийн даатгал	Орон сууцны урт хугацааны зээл (моргэйж)-ийн гэрээний зээлдэгчээс бусад зээлдэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчдаатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдагдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлаас бусад буюу зөвхөн зээл төлөх нөхцөл хамаарна.Зээлдэгч төлбөрийн чадваргүй болох эрсдэлийн даатгал, хэрэглээний зээл, автомашины

		зээл, бизнесийн зээл, цалингийн зээл зэрэг зээлийн даатгал энэ хэлбэрт хамаарна. Зээлийн барьцаа хөрөнгийн даатгал үүнд хамаарахгүй.
	1.13.Итгэлцлийн даатгал	Аливаа гэрээ, хэлцлээр хүлээсэн үүрэг зөрчигдсөнтэй холбоотой үүсэх алдагдал, зардлыг даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Гүйцэтгэлийн баталгааны даатгал /performance insurance/, чин шударгын баталгааны /fidelity guarantee insurance/ даатгал үүнд хамаарна.
	1.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	Төмөр замын ба усан замын тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохиролучрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглахтай холбоотой аливаа осол, гэмтлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан нөхцөлд даатгагч даатгалын гэрээнд заасанэрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал.
	1.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	Агаарын тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглахтай холбоотой аливаа осол, гэмтлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан нөхцөлд даатгагч даатгалын гэрээнд заасанэрх бүхий этгээдэд мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал.

/ Энэ хавсралтын 1.17 – с 1.24 хүртэл хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 235 дугаар тогтоолоор нэмсэн/

Даатгалын ангилал	Даатгалын хэлбэр	Даатгалын хэлбэрийн тайлбар
	1.17. Факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал /Facultative quota share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрээр даатгагч болон давхар даатгагч хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг тодорхой хувь, хэмжээгээр хуваахаар харилцан тохиролцсон давхар даатгал.
	1.17.1. Гэнэтийн осол, эмчилгээний факультатив хувь оролцооны давхар даатгал	
	1.17.2. Хөрөнгийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
	1.17.3. Авто тээврийн хэрэгслийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	

Ердийн даатгал	1.17.4. Ачааны факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.5. Барилга угсралтын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.6. Газар тариалангийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.7. Мал амьтдын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.8. Агаарын хөлгийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.10. Хариуцлагын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.11. Санхүүгийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.12. Зээлийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.13. Итгэлцлийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.17.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
	1.18. Факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал /Facultative surplus share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрийг харилцан адилгүй хэмжээ, хувиар, даатгагчийн өөрийн хүлээх хариуцлагын доод хэмжээ болон давхар даатгагчид шилжүүлэх дээд хэмжээг зааж, хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг шууд хамааралтайгаар даатгагч болон давхар даатгагч харилцан тохиролцсоны үндсэн дээр хуваалцах давхар даатгал	
	1.18.1.Гэнэтийн осол, эмчилгээний факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.2.Хөрөнгийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.3.Авто тээврийн хэрэгслийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.4.Ачааны факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.5.Барилга угсралтын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.6.Газар тариалангийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.7.Мал амьтдын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.8.Агаарын хөлгийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.9.Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.10. Хариуцлагын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.11. Санхүүгийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.12. Зээлийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
	1.18.13. Итгэлцлийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал		
1.18.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн факультатив			

илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.18.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.18.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.19. Факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал /Facultative excess of loss reinsurance/	Даатгалын эрсдэлийн тодорхой хэмжээний босгоос давсан хэсгийг давхар даатган, урьдчилан тогтоосон хязгаарт багтаан нөхөн төлбөр даатгагчид олгохоор даатгагч болон давхар даатгагч харилцан тохиролцсон давхар даатгал
1.19.1.Гэнэтийн осол, эмчилгээний факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.2.Хөрөнгийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.3.Авто тээврийн хэрэгслийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.4.Ачааны факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.5.Барилга угсралтын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.6.Газар тариалангийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.7.Мал амьтдын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.8.Агаарын хөлгийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.9.Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.10. Хариуцлагын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.11. Санхүүгийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.12. Зээлийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.13. Итгэлцлийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.19.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.20. Факультатив хохирлыг зогсоох давхар даатгал /Facultative stop-loss reinsurance/	Даатгагч тодорхой заасан хугацаанд урьдчилан тохиролцсон нийт хязгаар хүртэл бүх хохирлыг төлж, даатгагчийн тухайн хугацаанд өөртөө авч үлдсэн хохирлын нийлбэр дүнгээс давсан хэсгийг давхар даатгагч тодорхой хувь хэмжээгээр даатгагчид нөхөн төлөхөөр харилцан тохиролцсон давхар даатгал
1.20.1.Гэнэтийн осол, эмчилгээний факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.2.Хөрөнгийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.3.Авто тээврийн хэрэгслийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	

1.20.4.Ачааны факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.5.Барилга угсралтын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.6.Газар тариалангийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.7.Мал амьтдын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.8.Агаарын хөлгийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.9.Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.10. Хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.11. Санхүүгийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.12. Зээлийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.13. Итгэлцлийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.20.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
1.21. Гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал /Treaty quota share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрээр даатгагч болон давхар даатгагч хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг тодорхой хувь, хэмжээгээр хуваан заавал давхар даатгах, даатгуулахаар харилцан тохиролцсон давхар даатгал.
1.21.1.Гэнэтийн осол, эмчилгээний гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.2.Хөрөнгийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.3.Авто тээврийн хэрэгслийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.4.Ачааны гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.5.Барилга угсралтын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.6.Газар тариалангийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.7.Мал амьтдын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.8.Агаарын хөлгийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.9.Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.10. Хариуцлагын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.11. Санхүүгийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.12. Зээлийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.13. Итгэлцлийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.21.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	

1.21.16.	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
1.22.	Гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал /Treaty surplus share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрийг харилцан адилгүй хэмжээ, хувиар, даатгагчийн өөрийн хүлээх хариуцлагын доод хэмжээ болон давхар даатгагчид шилжүүлэх дээд хэмжээг зааж, хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг шууд хамааралтайгаар даатгагч болон давхар даатгагч хуваан, заавал давхар даатгах, даатгуулахаар харилцан тохиролцсон давхар даатгал
1.22.1.	Гэнэтийн осол, эмчилгээний гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.2.	Хөрөнгийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.3.	Авто тээврийн хэрэгслийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.4.	Ачааны гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.5.	Барилга угсралтын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.6.	Газар тариалангийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.7.	Мал амьтдын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.8.	Агаарын хөлгийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.9.	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.10.	Хариуцлагын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.11.	Санхүүгийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.12.	Зээлийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.13.	Итгэлцлийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.14.	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.15.	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.22.16.	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
1.23.	Гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал /Treaty excess of loss reinsurance/	Даатгалын эрсдэлийн тодорхой хэмжээний босгоос давсан хэсгийг давхар даатган, урьдчилан тогтоосон хязгаарт багтаан нөхөн төлбөр даатгагчид олгох нөхцөлөөр даатгагч болон давхар даатгагч заавал давхар даатгуулах, даатгахаар харилцан тохиролцсон давхар даатгал
1.23.1.	Гэнэтийн осол, эмчилгээний гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.23.2.	Хөрөнгийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.23.3.	Авто тээврийн хэрэгслийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.23.4.	Ачааны гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.23.5.	Барилга угсралтын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.23.6.	Газар тариалангийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.23.7.	Мал амьтдын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
1.23.8.	Агаарын хөлгийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	

	1.23.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.23.10. Хариуцлагын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.23.11. Санхүүгийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.23.12. Зээлийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.23.13. Итгэлцлийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.23.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.23.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.23.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	1.24. Гэрээт хохирлыг зогсоох давхар даатгал /Treaty stop-loss reinsurance/	Даатгагч тодорхой заасан хугацаанд урьдчилан тохиролцсон нийт хязгаар хүртэл бүх хохирлыг төлж, даатгагчийн тухайн хугацаанд өөртөө авч үлдсэн хохирлын нийлбэр дүнгээс давсан хэсгийг давхар даатгагч тодорхой хувь хэмжээгээр даатгагчид нөхөн төлөх нөхцөлөөр давхар даатгагч болон даатгагч заавал давхар даатгах, даатгуулахаар харилцан тохиролцсон давхар даатгал
	1.24.1. Гэнэтийн осол, эмчилгээний факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.2. Хөрөнгийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.3. Авто тээврийн хэрэгслийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.4. Ачааны факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.5. Барилга угсралтын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.6. Газар тариалангийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.7. Мал амьтдын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.8. Агаарын хөлгийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.10. Хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.11. Санхүүгийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.12. Зээлийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.13. Итгэлцлийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	1.24.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
2. Урт	2.1.Хугацаат амьдралын	Даатгуулагчзөвхөн даатгалтай хугацаанд нас барсан

хугацааны даатгал	даатгал	тохиолдолд даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч мөнгөн төлбөртөлөх нөхцөл бүхий даатгал. Орон сууцны урт хугацааны зээл (моргэйж)-ийн гэрээний зээлдэгчийн амь насны даатгал үүнд хамаарна.
	2.2.Насан туршийн даатгал	Даатгуулагч зөвхөн нас барсан тохиолдолддаатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхийдаатгал.
	2.3.Хуримтлалын даатгал	Даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьдбайх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгуулагч,эсвэл гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч баталгаатай мөнгөн төлбөр төлөх хугацаат даатгалболон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгал. Гэрлэлтийн, сургалтын зардлын, орон сууцны хуримтлалын даатгал үүнд хамаарна.
	2.4.Тэтгэврийн даатгал	Даатгалын гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчидтэтгэвэр буюу мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
	2.5.Эрүүл мэндийн даатгал	Эрүүл мэндийн холбогдолтой зардлыг даатгалын гэрээгээр даатгуулагчид төлөх нөхцөл бүхийдаатгал.Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал хамаарна.
	2.6.Аннуити даатгал	Даатгагч гэрээгээр тохиролцсонхугацаанд даатгуулагчид үечилсэн байдлаар тогтмол мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.

/ Энэ хавсралтын 2.7 – с 2.14 хүртэл хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 235 дугаар тогтоолоор нэмсэн/

Даатгалын ангилал	Давхар даатгалын хэлбэр	Даатгалын хэлбэрийн тайлбар
	2.7. Факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал /Facultative quota share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрээр даатгагч болон давхар даатгагч хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг тодорхой хувь, хэмжээгээр хуваахаар харилцан тохиролцсон давхар даатгал.
	2.7.1. Хугацаат амьдралын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
	2.7.2. Насан туршийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
	2.7.3. Хуримтлалын факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
	2.7.4. Тэтгэврийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
	2.7.5. Эрүүл мэндийн факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
	2.7.6. Аннуити факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	

Урт хугацааны даатгал	2.8. Факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал /Facultative surplus share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрийг харилцан адилгүй хэмжээ, хувиар, даатгагчийн өөрийн хүлээх хариуцлагын доод хэмжээ болон давхар даатгагчид шилжүүлэх дээд хэмжээг зааж, хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг шууд хамааралтайгаар даатгагч болон давхар даатгагч харилцан тохиролцсоны үндсэн дээр хуваалцах давхар даатгал
	2.8.1. Хугацаат амьдралын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
	2.8.2. Насан туршийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
	2.8.3. Хуримтлалын факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
	2.8.4. Тэтгэврийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
	2.8.5. Эрүүл мэндийн факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
	2.8.6. Аннуити факультатив илүүдлийн оролцооны давхар даатгал	
	2.9. Факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал /Facultative excess of loss reinsurance/	Даатгалын эрсдэлийн тодорхой хэмжээний босгоос давсан хэсгийг давхар даатган, урьдчилан тогтоосон хязгаарт багтаан нөхөн төлбөр даатгагчид олгохоор даатгагч болон давхар даатгагч харилцан тохиролцсон давхар даатгал
	2.9.1. Хугацаат амьдралын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	2.9.2. Насан туршийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	2.9.3. Хуримтлалын факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	2.9.4. Тэтгэврийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	2.9.5. Эрүүл мэндийн факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	2.9.6. Аннуити факультатив хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
	2.10. Факультатив хохирлыг зогсоох давхар даатгал /Facultative stop-loss reinsurance/	Даатгагч тодорхой заасан хугацаанд урьдчилан тохиролцсон нийт хязгаар хүртэл бүх хохирлыг төлж, даатгагчийн тухайн хугацаанд өөртөө авч үлдсэн хохирлын нийлбэр дүнгээс давсан хэсгийг давхар даатгагч тодорхой хувь хэмжээгээр даатгагчид нөхөн төлөхөөр харилцан тохиролцсон давхар даатгал
	2.10.1. Хугацаат амьдралын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	2.10.2. Насан туршийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	2.10.3. Хуримтлалын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	2.10.4. Тэтгэврийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
	2.10.5. Эрүүл мэндийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
2.10.6. Аннуити факультатив хохирлыг зогсоох давхар даатгал		
2.11. Гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал /Treaty quota share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрээр даатгагч болон давхар даатгагч хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг тодорхой хувь, хэмжээгээр хуваан заавал давхар даатгах, даатгуулахаар харилцан тохиролцсон давхар даатгал.	
2.11.1. Хугацаат амьдралын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		
2.11.2. Насан туршийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал		

2.11.3. Хуримтлалын гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
2.11.4. Тэтгэврийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
2.11.5. Эрүүл мэндийн гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
2.11.6. Аннуити гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал	
2.12. Гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал /Treaty surplus share reinsurance/	Даатгалын гэрээ тус бүрийг харилцан адилгүй хэмжээ, хувиар, даатгагчийн өөрийн хүлээх хариуцлагын доод хэмжээ болон давхар даатгагчид шилжүүлэх дээд хэмжээг зааж, хураамж, хохирол, хохиролтой холбоотой нийт зардлыг шууд хамааралтайгаар даатгагч болон давхар даатгагч хуваан, заавал давхар даатгах, даатгуулахаар харилцан тохиролцсон давхар даатгал
2.12.1. Хугацаат амьдралын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
2.12.2. Насан туршийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
2.12.3. Хуримтлалын гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
2.12.4. Тэтгэврийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
2.12.5. Эрүүл мэндийн гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
2.12.6. Аннуити гэрээт илүүдлийн оролцооны давхар даатгал	
2.13. Гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал /Treaty excess of loss reinsurance/	Даатгалын эрсдэлийн тодорхой хэмжээний босгоос давсан хэсгийг давхар даатган, урьдчилан тогтоосон хязгаарт багтаан нөхөн төлбөр даатгагчид олгох нөхцөлөөр даатгагч болон давхар даатгагч заавал давхар даатгуулах, даатгахаар харилцан тохиролцсон давхар даатгал
2.13.1. Хугацаат амьдралын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
2.13.2. Насан туршийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
2.13.3. Хуримтлалын гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
2.13.4. Тэтгэврийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
2.13.5. Эрүүл мэндийн гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
2.13.6. Аннуити гэрээт хохирлын хэтрэлтийн давхар даатгал	
2.14. Гэрээт хохирлыг зогсоох давхар даатгал /Treaty stop-loss reinsurance/	Даатгагч тодорхой заасан хугацаанд урьдчилан тохиролцсон нийт хязгаар хүртэл бүх хохирлыг төлж, даатгагчийн тухайн хугацаанд өөртөө авч үлдсэн хохирлын нийлбэр дүнгээс давсан хэсгийг давхар даатгагч тодорхой хувь хэмжээгээр даатгагчид нөхөн төлөх нөхцөлөөр давхар даатгагч болон даатгагч заавал давхар даатгах, даатгуулахаар харилцан тохиролцсон давхар даатгал
2.14.1. Хугацаат амьдралын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
2.14.2. Насан туршийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
2.14.3. Хуримтлалын факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
2.14.4. Тэтгэврийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
2.14.5. Эрүүл мэндийн факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	
2.14.6. Аннуити факультатив хохирлыг зогсоох давхар даатгал	

Тайлбар: Даатгалын хэлбэр нь даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэх бөгөөд Даатгалын бүтээгдэхүүн гэдэгт даатгагчаас хэрэглэгчдэд санал болгож, худалдан борлуулж байгаа даатгалын үйлчилгээг ойлгоно. Жишээлбэл: Хүүхдийн гэнэтийн ослын даатгал нь гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын хэлбэрт хамаарах даатгалын бүтээгдэхүүн юм.